



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

“Эс Ай Би Эс” ХХК-д даатгалын зуучлагчийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.2, 11.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эс Ай Би Эс” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгагч болон даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Эс Ай Би Эс” ХХК /Д.Дашдулам/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000112